

БАТЛАВ

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Т. ДЭЛГЭРСАЙХАН

**КАМЕРЖУУЛАЛТ (НОГООН БҮС) АЖЛЫН ДААЛГАВАР
УГСРАЛТ СУУРИЛУУЛАЛТ /ДЭД БҮТЭЦ, КАМЕРЫН ХЯНАЛТЫН ӨРӨӨ,
ХЯНАЛТЫН КАМЕР/**

2023.10.08

Дугаар: 2023/2,3 -1

Ховд хот

№	Төсөл боловсруулах үндэслэл	Камержуулалт /Ногоон бүс/ Аймгийн ИТХ-ын 2023 оны 12/02 тогтоолын 2 дугаар хавсралт 2.3 дах арга хэмжээ
1	Байршил	Ховд аймаг Жаргалант сумын 12 багийн нутаг дэвсгэрт
2	Хөрөнгө оруулалт эх үүсвэр	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
2	Зориулалт, хүчин чадал	Жаргалант сумын хяналтын камерын нэгдсэн систем. 1. 89 цэгт эргэдэг камер 30, чиглэлийн камер 227 нийт 257 камер суурилуулах 2.Серверийн өрөөний засвар, түүний дагалдах төхөөрөмжүүд 3.Дэд бүтэц Шилэн кабель, цахилганы кабелийн холболт, дагалдах хэрэгслийн суурилуулалт
3	Зураг төсөв боловсруулахад ашиглах материал	Цахилгаан, холбооны зураг төсөл,угралт, суурилуулалтын “Арбэл Алтай ХХК” –ийн “Шифр АБ-А 09/0-23-ГХ”, “Шифр АБ-А 09/1-23-ГХ дугаартай ажлын зураг
4	Төсөл гүйцэтгэх хугацаа Зураг, төсөл зохиох үе шат хугацаа:	Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
5	Төслийн захиалагч	Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар
6	Хийгдэх ажил	Ховд аймгийн Жаргалант сумын гудамж талбай, олон нийтийн газар, байгууллага, аж ахуйн нэгжийн гадна болон дотор орчинд үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчил, гамшиг, аюул ослоос урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр нийт 89 байршилд эргэдэг, хөдөлгөөнт камер 30, чиглэлийн камер 227 нийт 257 камер суурилуулан шилэн кабелийн сүлжээгээр цагдаагийн газрын теле хяналтын серверийн өрөөнд холбоно. (Тоног төхөөрөмжийн тоо, хүчин чадал, техникийн үзүүлэлтийг хавсралт 1,2 –д харуулав) Теле хяналтын камерын систем нь: теле хяналтын төв, хяналтын камер, хяналтын байршил, систем, хяналтын камерын шон, цахилгаан, шилэн кабелийн дэд бүтэц гэсэн бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Телехяналтын төв: Телехяналтын төв нь бичлэг хадгалах төхөөрөмж, хяналтын дэлгэц, операторын

		<p>төхөөрөмж, сүлжээний төхөөрөмж, цахилгаан тэжээлийн төхөөрөмж, холболт, хөргөлтийн систем зэргээс бүрдэнэ. Бичлэгийн төхөөрөмж нь камерын бичлэгийг 30 хоногоос доошгүй хугацаатай хадгалахаар багтаамжтай сонгоно. Бичлэгийн төхөөрөмжинд камер удирдах гар холбогдох боломжтой байна. Хяналтын төвийн дэлгэцийн хэмжээтэй ижил дэлгэц сонгоно. /тусгай зориулалтын ханын дэлгэц байна./ Дэлгэц нь дүрсний бүх төрлийн холболтын оролтуудтай, зориулалтын суурин дээр бэхэлж суурилуулна.</p> <p>Теле хяналтын байршил: Төхөөрөмжийн хайрцаг нь тухайн цэгийн тоног төхөөрөмжүүдийг (сүлжээний төхөөрөмж, хүчдэл тогтворжуулагч, цахилгаан болон шилэн кабелийн холболт монтаж гэх мэт) багтаах зай хэмжээтэй байна.</p> <p>Тоос, шороо, ус, чийгний хамгаалалттай зориулалтын хайрцаг байна.</p> <p>Хяналтын камерын шон: Шонгийн өндөр хяналтын байршлаас хамааран 8-с багагүй метрийн өндөр төмөр, зориулалтын гартай, 5—6 метрийн өндөрт хяналтын камерыг суурилуулах, гэрэлтүүлэг, камер хосолсон бетон хийцлэлтэй стандарт шон байна.</p> <p>Тоног төхөөрөмжийн хайрцаг, хяналтын камер суурилуулах гартай байна.</p> <p>Дэд бүтэц: Хяналтын цэгийг байнгын цахилгаан тэжээлтэй, найдвартай эх үүсвэрээс стандартын дагуу холбоно. Хяналтын цэгүүдийг шилэн кабелийн сүлжээгээр хяналтын төвд холбох ба хоорондын хамааралгүй шилэн кабелиар холбогдсон байна.</p> <p>Бусад: Баталгаат хугацаанд нийлүүлсэн тоног төхөөрөмжийн гэмтлийг бүрэн хариуцна. Нийлүүлсэн тоног төхөөрөмжүүдийг захиалагчийн байранд суурилуулж 72 цаг тасралтгүй ажиллуулан шалгасны дараа хүлээлгэж өгнө.</p> <p>Суурилагдах бүх тоног төхөөрөмж нь 220В, 50Гц±5% хүчдэлд ажилладаг байхаар сонгоно. Төхөөрөмжүүд нь 7/24/365 өдөр байнгын тасралтгүй ажиллах чадвартай байхаар сонгоно.</p> <p>Олон улсын чанарын шаардлага хангасан тоног, төхөөрөмжүүд байна.</p> <p>Теле хяналтын камерын цэгт суурилуулсан тоног төхөөрөмжийн жагсаалт, сүлжээний болон цахилгааны холболтын ажлын зургийг гаргаж цагдаагийн газрын мэдээлэл, холбооны инженерт хүлээлгэн өгч, акт үйлдэж баримтжуулна.</p>
	<p>Техникийн үндсэн нөхцөл</p>	<p>Цахилгааны холболтыг ХОВД ЦТС ХХК-аас зөвшөөрөл / техникийн нөхцөл/ авч гүйцэтгүүлэх шаардлагатай. Шилэн кабелийн холболтыг худаг сувагчлалаар гүйцэтгэх тохиолдолд МХС ТӨК-аас техникийн нөхцөл авах Гэрэлтүүлгийн шон ашиглаж камер, шилэн кабель суурилуулах тохиолдолд хот тохижуулах газраас техникийн нөхцөл авах</p>

7	Онцгой нөхцөл	<p>Гадна инженерийн шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй. 3Т 7.4 заалт</p> <p>Мөрдөх хууль, стандарт, норм, дүрэм</p> <p>Харилцаа холбооны тухай хууль</p> <p>Барилгын тухай хууль</p> <p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль</p> <p>Кибер аюулгүй байдлын тухай хууль</p> <p>Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль</p> <p>Холбооны кабель шугамын ажлын зураг төсөл MNS 6305:2012,</p> <p>Мэдээлэл, холбооны дотоод сүлжээ, дохиолол, хяналтын системийн төхөөрөмжийн тэмдэглэгээ MNS 5532:2022</p> <p>Цахилгаан байгууламжийн дүрэм БД 43-101-03</p> <p>Мэдээллийн технологи. Аюулгүй байдлын арга техник. Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо. Шаардлага MNS ISO/IEC 27001:2021</p> <p>Дата төвийн харилцаа холбооны болон бусад дэд бүтцийн шаардлага MNS 6528:2021</p> <p>Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНбд 30.01.04</p> <p>Шилэн кабелийн угсралтын ажлыг харилцаа холбооны зохицуулах хорооноос олгосон харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх,</p>
---	---------------	---

ХБТХО ХЭЛТСИЙН ДАРГА

ХЯНАСАН:

Б.БАЯРСҮХ

ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

Г.ЦООДОЛ

ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА,

Д.ОТГОНБИЛЭГ

БОЛОВСРУУЛСАН:

ЦАГДААГИЙН ГАЗРЫН ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН
АХЛАХ ИНЖЕНЕР

Б.МӨНХТУЛГА

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
УЛСЫН БАЙЦААГЧ

Б.БАТ-ОЮУН

